

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2018 оны 02 дугаар
сарын 08-ний өдөр

Дугаар: 03

Улаанбаатар хот

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан төрийн бодлого, хууль тогтоомж боловсруулах, шийдвэр гарах үйл явцад иргэдийн цахим оролцоог хангах боломжийг бүрдүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын яам, агентлагуудад Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөл ЗӨВЛӨМЖ болгох нь:

1. Монгол Улсад мэдээллийн технологийн чиглэлээр улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн явц, хэрэгжилтийн талаарх тайланг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт ирүүлэх.

2. Монгол Улсад мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, цахим боловсрол, цахим эрүүл мэнд, ухаалаг засаг болон цахим бүртгэлийн төслүүд төрийн үйл ажиллагааг иргэн төвтэй болгох бодлоготой хэрхэн уялдаж байгаа талаар дүгнэлт гаргаж цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөлийн даргад танилцуулахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга /Б.Чинбат/-д үүрэг болгов.

3. Цаашид хэрэгжүүлэх мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөрт Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас санал авах.

4. Цахим засгийн хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр ажиллахыг Хууль зүй яамны Хууль зүйн бодлогын газрын дарга /П.Сайнбаяр/, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга /Б.Чинбат/-д чиглэл болгов.

5. “Төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн цахим оролцоог хангах экосистем” төслийн санхүүжилтын тооцоо хийж танилцуулахыг Үндэсний дата төв УТҮГ-ын дарга /Б.Батжаргал/-д үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ЗАНДАНШАТАР